

МОНГОЛД ХЯТАД ХЭЛ ДЭЭР ГАРСАН “АЖИЛЧНЫ ЗАМ” СОНИНЫ
ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Х.Ундрахбулаг*, Г.Оюунчимэг**

* МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн докторант

** СУИС-ийн РТМУС –ийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: МҮЭ, хятад ажилчид, “Ажилчны зам”, сонин, хэвлэх үйлдвэр, МОНЦАМЭ, “Монголын мэдээ”

Монголд 1921 оны Ардын хувьсгал ялахаас өмнө тус орны хүн амын дотор гадаадын олон үндэстэн ястан иргэншин сууж байв. Үүний дотроос хятад иргэд зонхилох байрыг эзэлж тэд Улаанбаатар, Ховд, Хэнтий, Сэлэнгэ, Төв, Улиастай зэрэг төв суурин газруудыг түшиглэн тариа ногоо тарьж, гар урлал, дэлгүүр хоршоо, хоолны газар ажиллуулж, худалдаа наймаа эрхлэн амьдарч байжээ.

XIX зууны сүүлч XX зууны эхэн үеэр Монгол улсын хүн амын тоо 639.700¹ байсны дунд хятад иргэд 100.000 шахам² байсан нь хүн амын 13.5 хувийг эзэлж, хүн амын нягтаршил ихтэй газруудад Хятадын харьяат нарын 34 гацаа суурин байжээ³.

Иймээс хятад иргэдэд оршин суугаа орныхоо болон Дундад улс, дэлхий дахины нийгэм улс төр, эдийн засгийн мэдээ мэдээлэл хязгаарлагдмал байсан нь өөрийн хэлний хэвлэлтэй болох нөхцөлийг бий болгожээ.

1925 онд хятад ажилчдын товчоо байгуулагдаж биеийн хүчээ үнэлэгч хятад иргэдийн эрх ашгийг хамгаала-

хын тулд тэднийг үндэснийхээ хэл дээр сурч, соёлжих, нам засгийн бодлогыг таниулахтай холбогдуулан биеэ даасан сонин гаргах нь чухал болохыг Монгол улсын нам, засгийн газраас ихэд анхааран үзжээ.

Үүний үр дүнд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлийн шууд удирдлагын доор 1929 оны 9 дүгээр сарын 1-нд хятад иргэдэд зориулсан “Ажилчны зам” нэртэй сонин анх удаа хятад хэлээр хэвлэгдэн гарчээ. Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл нь энэхүү сониныг “Ажилчны зам” гэж нэрлэсэн явдал бол тухайн үед Зөвлөлт Холбоот Улсын Владивосток хотод оршин суугч хятадын харьяат ажилчдын гаргаж байсан “Ажилчны зам” гэдэг сонины нэрийг авч хэрэглэсэн бололтой. Хуучнаар ЗХУ-ын Алс Дорнодын хязгаар нутагт амьдарч ажиллаж байсан хятад иргэдэд зориулж “Гунжэнь чжилу” буюу “Ажилчны зам” (工人之路, Gōngrén zhīlù, “Рабочий путь”) гэсэн нэртэй нийгэм-улс төрийн сонин 1922 онд анх Чити мужид эхний дугаар нь гарч, дараа нь Хабаровскт мөн 1924-1938 он хүртэл Владивостокт хятад хэл дээр гарчээ. 1933 онд 7000 мянган хувь хүртэл хэвлэгдэж байсан байна.

“Ажилчны зам” сонины гол зорилго нь Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлийн шууд удирдлагын доор МАХН, Ардын засгийн газраас гаргасан бүхий л хууль, дүрэм тогтоол, бодлогыг сурталчлах, хятад иргэдийг интернационалист үзэл суртлаар хүмүүжүүлэх, Монгол–Хятадын ард түмний найрамдлын харилцааг зузаатган бэхжүүлэх, хятадын ард түмнээс өөрийн эх орондоо социализм байгуулж байгаа үсрэнгүй хөгжил, Зөвлөлт Холбоот Улс тэргүүтэй ах дүү ардчилсан орнуудын хөгжил зэрэг дэлхий дахинд болж байгаа чухал зүйлүүдийг нийтлэх...”⁴ гэсэн чиглэлээр нийтлэлийнхээ үндсэн бодлогыг баримталж байв.

Тэр үеийн нэгэн томоохон хэвлэл “Монголын ажилчны зам” сонины редакцын өгүүлэлд “Ажилчны зам” сонины ач холбогдлын тухай бичихдээ: “Ажилчны зам” сонин бол Монгол Ардын Хувьсгалт Нам, Ардын засаг, Монголын үйлдвэрчний эвлэлээс өөрийн орны доторх засаг захиргаа, худалдаа үйлдвэр, олон нийтийн газруудад биеийн хүчин үнэлэн амьдарч байсан хятад ажилчдын хувьсгалын боловсрол, хүмүүжлийг сайжруулах хийгээд тэдгээр нь ямар ч дарлагдал мөлжигдөлгүй харин хувьсгалт орны дотор өөрсдийн эрх мэдлээр энх тайван орших завшаантайгаар амьдран чадаж байгаа. Хойшид ч Монголын хувьсгалт нам засгийн агуу ялалт хийгээд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн хувьсгалт удирдлага хүмүүжил тогтоосон хууль бүхий эрх ашгийн гүн хамгааллын доор багтах зэргийг сайтар тайлбарлан таниулбаас зохих...”⁵ гэж онцлон тэмдэглэжээ.

“Ажилчны зам” сонин нь монгол дахь хятад ажилчдын хүмүүжлийн гол индэр болж тэдэнд үндэснийхээ хэл


дээр сурч соёлжиход чухал бололцоог олгож байв. “Монгол оронд гадаад хэлээр гарч байсан тогтмол хэвлэлийн нэг нь 1929 оны 9-р сараас эхлэн хятад хэлээр хэвлэгдсэн “Ажилчны зам” сонин юм. Манай оронд байнга оршин сууж аж ахуйн янз бүрийн салбарт ажиллаж байгаа хятад иргэдэд нам засгийн бодлого шийдвэрийг тайлбарлан таниулах тэдний мэдлэг боловсрол, идэвх ухамсрыг ахиулахад уг сонины нийтлэл чиглэж байжээ.”⁶ хэмээн судлаач онцлон тэмдэглэжээ.

Сониноор дамжуулан явуулж байгаа хүмүүжлийн ажилд хятад ажилчид идэвхтэй оролцож байсан жишээ олон байна. 1934 оны эхний 4 сард явуулсан хүмүүжлийн ажлын байдлаас үзэхэд зөвхөн хятад клубийн ажилчдаас монгол хэлний хичээлд 10 гаруй, орос хэлний хичээлд 20 гаруй хүн суралцаж мөн улс төрийн дугуйланд 75, тоо бодлогод 10, ший жүжгийн дугуйланд 75 хүн тус тус суралцаж байжээ. Мөн намаас явуулж буй улс төрийн бодлогыг сайшаан Монголын ард түмний энх тайванч бодлогыг талархан улс орны батлан хамгаалах хэрэгт туслах зорилгоор өрнүүлсэн монголын ард түмний эх оронч хөдөлгөөнд нэмэр хандив оруулан хөрөнгө хуримтлуулж “Р-5” хэмээх нисэх онгоцыг Ардын хувьсгалын 14 жилийн ойгоор Монголын ард түмэнд бэлэглэж байсан”⁷ зэрэг баримтыг нэрлэж болно.

“Ажилчны зам” сонин нь эхэн үедээ жинхэнэ орон тооны эрхлэгч, ажилтан байгаагүй учир Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлийн хятад ажилчны асуудал эрхэлсэн тасаг хавсран ажиллаж монгол хэвлэл дээр гарсан чухал материалыг орчуулан нийтэлж байжээ. Энэ үед хоёр нүүр жижиг сонины дайтай, хэлбэр маяг, өнгө үзэмж, материалын байрлалын хувьд

төдий л хэлбэржээгүй байсан бөгөөд гаралт нь ч тогтмол бус, цинк дээр гараар бичиж гар ажиллагаатай машинаар хэвлэж байв.

1935 он хүртэл сониныг хариуцсан эрхлэгч, орон тооны ажилчид байгаагүй боловч сүүлдээ ажил нь нэлээд сайжирч 1941 оноос орон тооны нарийн бичгийн дарга, 1942 оноос орлогч эрхлэгчийн орон тоотой болж орлого зарлагаа тооцоолдог тусгай төсөвтэй, сониныг нийтлэхдээ гараар бичиж төмөр бараар хэвлэдэг болсон байна.



Зураг 1. “Ажилчны зам” сонин хэвлэгдсэн дугаарын тоо

Ингээд 1944 оны 4-р сараас эхлэн бие даасан сонины үйлдвэр болж жинхэнэ орон тооны эрхлэгч, нарийн бичгийн дарга нэг, сийрүүлэн бичих бичээч нэг, сонин түгээгч ажилчин нэгтэй болж сониноо тогтмол гаргадаг болжээ.

Жилдээ 48 дугаарыг 1935-1941 онуудад хэвлэж байснаа 1942 оноос 7 хоногт 5 дугаар гаргаж эхэлснээр 1954 он хүртэл тус сонин нь орон тоо, мэргэжлийн боловсон хүчин, үйлдвэрийн техникийн хувьд ихэд бэхжиж сонины захиалгын тоо жилээс жилд өсөж 1500-3100 хувьд хүрч байжээ.

1954 оны 4-р сард Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл нь тус сонины газрыг Хятадын харьяат иргэдийн нийгэмлэгийн зөвлөлд шилжүүлэн өгсний дараа сонины ажлыг сайжруулах зорилгоор 1955 оны намар БНХАУ-аас сонины ажилтан, үсэг өрөгч

зэрэг мэргэжилтнүүдийг урьж ирүүлжээ. Ингээд “Ажилчны зам” сонины газрын аппаратын зохион байгуулалтыг өргөтгөж орон тооны дарга нэг, ерөнхий редактор нэг, редактор хоёр, сурвалжлагч орчуулагч тус бүр нэг, үсэг өрөх ба хэвлэх цех нь нийтдээ 10 гаруй хүнтэй болж хэвлэх тасагтаа хэвлэх машин гурав, үсэг цутгах машин гурав, цаас хэрчих машин, хээ маягт хийх машин, даралтын машин, гуулин том жижиг хэв, арав гаруй мөн дугтуй, үлгэрчилсэн үсэг зэрэг тоног хэрэгсэлтэй болсон нь томоохон хэвлэх үйлдвэрийн хэмжээнд хүрчээ.

“Ажилчны зам” сонин хятад ажилчдын дунд захиалагддаг байсан ба монгол улсын бүтээн байгуулалтад оролцох хятад ажилчид олноор ирсэн нь тус сонины захиалагчдын тоо төдий чинээ нэмэгдэж байжээ.

1960-аад оны үед “Ажилчны зам” сонины эрхлэгчээр Лин Жао Шин, ерөнхий редактораар Сүн Бин Жюн⁸ нар ажиллаж байх хугацаандаа сонины орчуулагч, редакторууд зэрэг мэргэжлийн боловсон хүчнийг БНХАУ-аас урьж ирүүлэх, ажилчдын ур чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарч байв.

Сонины дизайны хувьд “Мэдээллийг аль болох график дүрст тэмдэгтээр илэрхийлэх, уншигчдад аятай таатай мэдээллийн орчныг бий болгох зорилго нь сонины дизайны хууль болно.”⁹ гэж судлаач тодорхойлжээ. Үүнээс үзэхэд:

“Ажилчны зам” сонины нэрийг хятад, монгол хоёр хэл дээр бичиж, “Орон бүхний пролетари нар нэгдэгтүн” гэсэн уриатай. Сонины хүрээ шугамын баруун дээд буланд хэдэн оноос хэвлэгдэж эхэлсэн, 7 хоногт хэдэн удаа гардаг, хэвлэгдсэн он, сар өдөр, хаанаас эрхлэн гаргадаг, сонины үнийг бичсэн байна.




Зураг 2. “Ажилчны зам” сонин.

Сонины хэмжээ 2/1 бөгөөд нэг удаагийн сонин бүр Хятадын 16000 үсгийн тэмдэгт хэрэглэдэг. Тус сонинг захиалах жилийн төлбөр нь 25 төгрөг байсан нь тухайн үед нэлээд үнэтэй хэвлэлийн тоонд орж байжээ.



Зураг 3. “Ажилчны зам” сонины дугаарууд

“Ажилчны зам” сонины нэг жилийн дугаарыг ажиглахад, сонин хэд хэдэн булантай улс төр, эдийн засаг, дотоодын болон дэлхийн мэдээ, соёл гэгээрэл, утга зохиолын бүтээлүүд, цаг уурын мэдээ, зар мэдээг хэвлэн нийтэлдэг байсан бөгөөд үүнээс хамгийн өндөр хувьтай нь дэлхий дахины мэдээ мэдээлэл байна.



Зураг 4. 1962 онд “Ажилчны зам” сонин нийт 145 дугаар гаргасны сэдвийн бүтэц¹⁰

“Ажилчны зам” сонинд тус сонины ажилтнуудаас гадна идэвхтэн бичигчдийн дотор тухайн үед “Хятад ажилчны клуб”-т ажиллаж байсан БНХАУ-ын орчин үеийн симфони хөгжмийг үндэс-

лэгч Сянь Синхай (冼星海), тус улсаас БНМАУ-д сууж байсан анхны Бүрэн Эрхт Элчин сайд Жи Яатай нар сонины нийтлэлд өөрийн биеэр оролцож мэдээ, мэдээлэл нийлүүлдэг байжээ.

Хятад ажилчны клуб”-т 1942 оны үед хөгжмийн багшаар ажиллаж байсан Сянь Синхай /1902-1945/ нь Хятадын орчин үеийн симфони хөгжмийг үндэслэгчдийн нэг, нэрт хөгжмийн зохиолч юм. Тэрээр Ший-Юаяньзд түүний бичсэн алдарт “Шар мөрний магтуу” симфонийг тоглож байжээ. Энэхүү симфонийн пьазны бичлэг нь Монголын театрын музейн сан хөмрөгт хадгалагдаж байдаг.

Ван Ши /Жи Яатай/ нь Хятад ажилчны клубт 1940-өөд оны үед клубийн дарга, найруулагчаар ажиллаж олон арван ший жүжгүүдийг найруулан тавьжээ. 1950 онд Монголд суух анхны Элчин сайдаар томилогдож иржээ.

Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 1964 оны 6-р сарын 5-ний өдрийн 19/99-р”¹¹ тогтоол ёсоор “Ажилчны зам” сониныг эд хогшил, орон барилгын хамт МОНЦАМЭ-д албан ёсоор шилжүүлжээ.

Хятад хэл дээр хэвдэгддэг байсан “Ажилчны зам” сонин 1964 оны 10 дугаар сараас эхлэн МОНЦАМЭ агентлагийн мэдэлд очиж “Мөнгү Шяоши Бао” /”Монголын мэдээ”/ нэртэйгээр өнөөг хүртэл хэвлэгдэн гарч Монгол-Хятадын хэвлэл мэдээллийн харилцаа, хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

Дүгнэлт:

1. Монгол оронд амьдарч, ажиллаж байсан хятад иргэд өөрийн эх хэл дээр мэдээ мэдээлэл олж авах, сурч боловсрох, соёлжих мэдээллийн гол хэрэгсэл нь “Ажилчны зам” сонин байлаа.
2. “Ажилчны зам” сонин нь хятад хэл дээр хэвлэгдсэн Монголын анхны сонин юм.
3. “Ажилчны зам” сонин нь Монгол – Хятад хоёр орны найрамдалт харил-

цааг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл.

4. “Ажилчны зам” сонин нь Монгол улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан ач холбогдол бүхий хэвлэл юм.
5. 1929 оноос эхлэн хэвлэгдсэн “Ажилчны зам” сониныг Монгол–Хятадын сэтгүүл зүйн түүхэн судалгааны эргэлтэд оруулах шаардлага өнөөдөр бидний өмнө нээлттэй байна.

Эшлэл

- ¹ Монгол улсын хүн ам ХХ зуунд. УБ. 1998. х.78.
- ² БНМАУ-ын түүх. Дэд боть. УБ.1968. х.183
- ³ О.Пүрэв. Монгол улсын түүхэн газар зүй. УБ. 2004. х.84-85.
- ⁴ МУУТА Н-535. Д-1. ХН-2539. х.88.
- ⁵ “Монгол ажилчны зам”. 1934. №19.
- ⁶ Л. Норовсүрэн. “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм” тэргүүн боть. УБ. 2000
- ⁷ Ч.Алагсай. Үйлдвэрчний эвлэлийн хэвлэл. УБ. 1968. х.41.
- ⁸ МУУТА Н-535. Д-1. ХН-2539. х.73.
- ⁹ Б.Болд-Эрдэнэ. Сонины дизайн. УБ. 2004. х.41.
- ¹⁰ МУУТА Н-535. Д-1. ХН-2549. х.7-9.
- ¹¹ МУУТА Н-535. Д-1. ХН-2538. х.17.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Алагсай Ч. Үйлдвэрчний эвлэлийн хэвлэл. УБ. 1968.
2. Батболд Ш. Монголын тухай мэдээлэл нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллахад бэлэн. [Монголын мэдээ](#)
3. Болд-Эрдэнэ Б. Сонины дизайн. УБ. 2004.
4. БНМАУ-ын Шинжлэх ухааны академи, Түүхийн хүрээлэн. БНМАУ-ын Соёлын түүх /1941-1960/. УБ. 1986.
5. БНМАУ-ын их, бага хурлын тогтоол. УБ. 1956.
6. БНМАУ-ын түүх. Дэд боть. УБ.1968.

7. Дүгэрсүрэн Л. Улаанбаатар хотын түүхээс. Нийслэл Хүрээ УБ. 1956.
8. Майский И М. Монголии накануне революций. М. 1959.
9. Монгол улсын хүн ам ХХ зуунд. УБ. 1998.
10. Монголын Үйлдвэрчний Эвлэл. Уриалга УБ. 1927.
11. Монголын Үйлдвэрчний Эвлэлийн дүрэм. УБ. 1929.
12. “Монгол ажилчны зам”. 1934. №19.
13. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ. 2000.
14. Пүрэв О. Монгол улсын түүхэн газар зүй. УБ. 2004.
15. Сандаг Ш. Монголын улс төрийн гадаад харилцаа /1850-1919/. УБ.1971.
16. “Ажилчны зам” сонин. 1961 он.
17. МУУТА Х-349, Т-1, ХН-80
18. МУУТА Х-535, Т-1, ХН 2525
19. МУУТА Х-535, Т-1, ХН 2532
20. МУУТА Х-535, Т-1, ХН 2538
21. МУУТА Х-535, Т-1, ХН2539
22. МУУТА Х-535, Т-1, ХН 2549

Summary

Newspaper is the type of the mass media that has an advantage over other types in that the information can be reread. The newspaper which managed to preserve such a characteristic is «The workers' way», which provides information and support to the Chinese citizens residing in Mongolia. In this article, the author discusses roles of “The workers' way” newspaper for Chinese citizens who were living in Mongolia that time and two countries' cooperation.